



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/368

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 214 дүгээр
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 8,644,717 (найман сая зургаан зуун дөчин дөрвөн мянга долоон зуун арван долоо) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 214 дүгээр цэцэрлэг (Д.Отгонжаргал)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн 891,200 (найман зуун ерэн нэгэн мянга хоёр зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 5 нэр төрлийн 7,753,517 (долоон сая долоон зуун тавин гурван мянга таван зуун арван долоо) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 214 дүгээр цэцэрлэг (Д.Отгонжаргал)-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001037

Нийслэлийн Өмчийн ажиллалт, удирдлагын газрын даргын 2021 оны 11 дугаар сарын 21 -ны өдрийн А/268 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Сонгинохайрхан дүүргийн 214 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Цахилгаан пийшин	5	ш	1	2,500,000	2,500,000	2,500,000	-	эвдэрсэн	актлах	40,000	татах
2	Ус буцалгагч	5	ш	1	421,300	421,300	421,300	-	эвдэрсэн	актлах	2,000	устгах
3	Хөгжим	5	ш	1	469,900	469,900	469,900	-	эвдэрсэн	актлах	1,000	устгах
Машин тоног төхөөрөмжийн дүн				3		3,391,200	3,391,200				43,000	
4	Хүүхдийн ширээ	5	ш	35	64,600	2,261,000	2,261,000	-	эвдэрсэн	актлах	87,500	татах
5	Багш сандал	5	ш	9	24,780	223,017	223,017	-	эвдэрсэн	актлах	18,000	татах
6	Тумбочка	5	ш	2	80,750	161,500	161,500	-	эвдэрсэн	актлах	10,000	татах
7	Дрож	5	м	32	81,500	2,608,000	2,608,000	-	муудсан	актлах	32,000	татах
Тавилга, эд хогшлын дүн						5,253,517	5,253,517				147,500	
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						8,644,717	8,644,717					
Үүнээс: Худалдах хөрөнгө						891,200						
Актлах хөрөнгө				2								
Татан төвлөрүүлэх хөрөнгө				5		7,753,517						
Худалдсанаас олох орлого											190,500	
НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/											57,150.00	